




АТГАМҮӨДӨС ТУУЛГА

# ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2020 оны тавдугаар сарын  
байдлаар






## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

АУГАВГУУДС  
ТӨСӨВ



төсвийн орлогод  
эзлэх хувь 2020 оны  
5 сарын байдлаар





АТГАМГА  
МОНГОЛ



## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Банк

МОНГОЛ БАНК МЭДЭЭ / сая төгрөг /



2019 V

2020 V

65 998.3

НИЙТ ХАДГАЛАМЖ

73 912.8

110 888.8

ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ

112 056.5

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсч, 112 056.5 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1 452.3 сая төгрөг, чанаргүй зээл 1 342.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 94.2 хувиар, чанаргүй зээл 13.0 хувиар тус тус өссөн байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өсч, 73 912.8 сая төгрөг болсон ба мөн нийт харилцахын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар өсч 21 283.2 сая төгрөг болов.



Аж үйлдвэр  
түстэй



## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ /САЯ.ТӨГ/



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны 5 сарын байдлаар 3 453.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 15.4 хувиар буурсан байна.



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд



### Эмнэлэгт эмчлэгдэж гарсан хүний тоо, амбулаторийн үзлэгийн тоо

	2018 I-V	2019 I-V	2020 I-V
Эмчлэгдэн гарсан хүний тоо	5044	4920	4571
Амбулаторийн үзлэгийн тоо	74160	79392	79965

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 4571 эмчлүүлэгч хэвтэж, 4581 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 32368 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.1 байна. 2020 оны 5 сарын байдлаар 79965 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 29.2%, өвчний учир амбулаторийн үзлэг 49.4%, идэвхтэй хяналт 15.0%, гэрийн үзлэг 4.6%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 33.8 хувь нь эрэгтэй, 66.2 хувь нь эмэгтэй хүн байна.



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Амьдралын  
статистик

	Амаржсан эхийн тоо	Амьд төрсөн хүүхдийн тоо	0-1 насны хүүхдийн эндэгдэл	1-5 насны хүүхдийн эндэгдэл
2018 I-V	387	392	3	6
2019 I-V	374	377	0	0
2020 I-V	388	392	2	4

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2020 оны 5-р сарын байдлаар 388 эх төрсөн ба нийт 392 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 14 төрөлтөөр өссөн байна. Төрсөн эхчүүдийн 91.0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар 0-5 насны хүүхдийн 3 эндэгдэл гарсан байна.




АТГАВЧУУДЫН  
ТӨВӨН



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

### Бүртгэгдсэн халдварт өвчлөлийн тоо



2020 оны 5 сарын байдлаар халдварт өвчний 131 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 28.2 болж өмнөх оны мөн үеэс 60 тохиолдол буюу 12.7 пунктээр буурсан байна .



## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН, жил бүрийн 5 сарын байдлаар




	2018 V	2019 V	2020 V
Ажил хайгч иргэн	733	436	475
Үүнээс эмэгтэй	368	183	231

2020 оны 5 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 475 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 31.3 хувиар өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 48.6 хувь буюу 231 хүн нь эмэгтэйчүүд байна.



# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд, 2020 оны эхний 5 сарын байдлаар, сумаар



аймгийн хэмжээнд **147**


Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 147 ажил хайгч иргэн ногдож байхад Цагаандэлгэр 235, Говь-Угтаал 217, Өндөршил 341, Хулд 247, Луус 188, Гурвансайхан 224, Дэлгэрхангай 177, Сайхан-Овоо 219, Баянжаргалан 175, Эрдэнэдалай 177 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

Ажлын үндэсний статистик



# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

## НИЙГМИЙН ХАЛАМЖИД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО 2020 оны 5 сарын байдлаар



2020 оны эхний 5 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 16109 хүнд 2696.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна.

Ажлын үндэсний статистик



# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН ТОО,  
жил бүрийн 5 сарын байдлаар



БҮХ ХЭРЭГ



ХОЛБОГДОГЧ



Цагдаагийн хэлтсийн 2020 оны 5 сарын байдлаар Дундговь аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг 105 болж өмнөх оны мөн үеэс 3 хэргээр буюу 2.9 хувиар гэмт хэргийн гаралт өссөн байна. Гэмт хэрэгт нийт 65 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 холбогдогчоор буюу 30 хувь өссөн.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 286,5 сая төгрөг байна. 2020 оны 5 сард 7730 зөрчил шалгагдсан байна. Зөрчил гаргасан 7617 иргэнийг 242,2 мянган төгрөгөөр торгож тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасахаар 91 хүн, баривчлахаар 37 хүнд шийтгэл оноолоо.


АТГАМЬДАН  
ТӨСӨН



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

## Дундговь аймгийн хэрэглээний үнийн индекс (өмнөх оны 12 сар = 100)

—●— 2018 —●— 2019 —■— 2020



- Тус аймагт 2020 оны 5 сарын байдлаар өмнөх оны 12 сартай харьцуулахад хэрэглээний үнийн индекс 2.9 хувиар өсжээ. Хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 10.0 хувиар, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 2.9 хувиар, хувцас бөс бараа гутал 2.6 хувь, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлш 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 2.4 хувиар, эм тариа эмчилгээний бүлэг 2.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.




АТГАМГА  
МОНГОЛ



## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнэ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, /ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕТЭЙ ХАРЬЦУУЛСАНААР/



Тус аймагт 2020 оны 5 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний үнийн индекс 6.0 хувиар өсжээ. Хэрэглээний үнийн индекс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 8.5 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 3.3 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 9.3 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 7.8 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.6 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 2.9 хувиар өссөн, тээврийн бүлэг 3.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.



АТГАМГАД ТУУГАЙ



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах тоглоом



Валютын ханш



1212.mn аппликейнаас  
СТАТИСТИКИЙН  
мэдээллээ аваарай



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС